

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ			
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.			
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:			
1	4.2.9. Олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулсан байна.	<ul style="list-style-type: none"> - Гашуунсухайт боомтод жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал байгуулж, 2021.09.20-ны өдөр ашиглалтад оруулсан. - Шивээхүрэн боомтод 17 га талбайд 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилдээ 10 сая тн нүүрс экспортлох чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг Нарийн сухайтын нүүрсний бүлэг орд орчмын “Монголын Алт” ХХК тэргүүлсэн 8 аж ахуйн нэгж хийж гүйцэтгэн 2022 онд ашиглалтад оруулсан. - Засгийн газрын 2022 оны 27 дугаар тогтоолын дагуу Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0119 анги Замын-Үүд-Эрээн боомтын дундын бүсэд чингэлэг шилжүүлэн ачих талбайн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан. - Тавантолгойн холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж, логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” ХХК ажиллаж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 40%-тай явагдаж байна. - “Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төв байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байр зүйн зураг боловсруулах” гэрээт ажлын эхлэл болон дунд шатны тайланг дүгнэсэн. - Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Холимог тээврийн логистикийн төвийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 800 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг БХБЯ-нд хүргүүлсэн. 	100
2	4.2.10. Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> - “Агаарын харилцааны тухай” Монгол Улсын Засгийн газар Испанийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг 2021.07.27-ны өдөр үзэглэсэн. - Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газартай байгуулах “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцсон. - Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газартай байгуулах хэлэлцээрийн үзэглэсэн төсөлд техникийн шинжтэй өөрчлөлт оруулж Азербайжаны талаас ирүүлснийг хянан, англи, монгол хэл дээрх төслийг эцэслэн ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Азербайжан, Грек Улстай байгуулах “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-ийн үзэглэсэн төслийг дипломат шугамаар ноот бичиг солилцох замаар гарын үсэг зурж албажуулах саналыг айлын талд хүргүүлсэн. - Лавти, Унгар, Кувейтын талтай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах саналыг Монголын талын төслийн хамт Гадаад харилцааны яамаар дамжуулан тус тус хүргүүлсэн. - “Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод олгосон. -Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг үзэглэсэн. -Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын харилцааны хурал(ICAN 2022)-ын хүрээнд ИБУИНХУ-тай агаарын харилцааны хэлэлцээг цахимаар хийж “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, ИБУИНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг үзэглэсэн. -“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Латви Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцож, 2022 оны 12 дугаар сард багтаан цахимаар үзэглэхээр тохирсон. - Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газар хоорондын "Агаарын харилцааны тухай" хэлэлцээрийн үзэглэсэн төслийг орчин үеийн агаарын харилцааны эрх зүйн шаардлагад нийцүүлэн шинэчлэхээр тохиролцож, тус яам болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын Тээврийн яам хооронд хамтын ажиллагааны протокол үйлдсэн. Улмаар хэлэлцээрийн төсөлд зохих 	100

		<p>өөрчлөлтийг оруулж, Гадаад харилцааны яамаар уламжлуулан 2022.06.08-ны өдрийн 01/2672 тоот албан бичгээр Узбекистан улсын талд хүргүүлсэн.</p> <p><u>Нислэгийн цэг, давтамж нэмэгдүүлэх:</u></p> <p>- БНСУ-ын талтай Улаанбаатар-Сөүл чиглэлд 2022 оны зуны цагийн хуваариас эхлэн 6-9 дүгээр сард долоо хоногт тал тус бүр 5000 суудлын багтаамж буюу Монголын тал 20, Солонгосын тал 18 нислэг гүйцэтгэхээр, 5-10 дугаар сард долоо хоногт тал тус бүр 2500 суудлын багтаамж буюу Монголын тал 11, Солонгосын тал 9 нислэг гүйцэтгэх одоогийн тохиролцоог хэвээр хадгалахаар тохирч, санамж бичиг байгуулсан.</p> <p>- Улаанбаатар-Хонконг чиглэлийн нислэгийн давтамжийг долоо хоногийн 11 байсныг 15 болгож нэмэгдүүлсэн.</p> <p>- ОХУ-тай Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмж тохирч, нислэг гүйцэтгэх зохицуулалт бүрдүүлсэн.</p> <p>- Япон-Монголын нислэгийн давтамж долоо хоногийн 13.5 нэгж буюу 13 хүртэлх давтамж, үүнээс 7 давтамж нь Улаанбаатар-Токио чиглэлд ашиглагдаж байсныг Монгол-Япон хоорондын нислэгийн давтамжийг долоо хоногийн 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн.</p> <p>-Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын харилцааны хурал (ICAN 2022)-ын үеэр цахим хэлэлцээ хийж, Тайландын талтай зорчигч, ачаа тээврийн нислэгийн давтамжийг долоо хоногт тус бүр 7 удаа болгон нэмэгдүүлэх, Малайзын талтай аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтыг тохирсон.</p>	
3	<p>4.2.11. эрдэс баялгийн экспортын зонхилох эзэлж нүүрс, баяжмал, хүдэр, нефть нэмүү цэнэ боловсруулж, экспортлох хүрээнд байгуулалтыг оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Төмөр замын төслүүд, хилийн боомтуудыг холбох хатуу хучилттай авто замын төслүүдийн барилгын ажил, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилт тусгагдаагүй бөгөөд санхүүжилтийг шийдвэрлүүлэх чиглэлээр төлөвлөн дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:</p> <p><u>1. Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбох төсөл:</u></p> <p>Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг тогтоосон хэлэлцээрийг 2021.11.18-ны өдөр хоёр улсын Гадаад харилцааны яамдууд ноот бичиг харилцан солилцож байгуулсан.</p> <p>Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын асуудлаар Монгол-Хятадын хоёр талын газрын дарга нарын түвшний цахим уулзалтыг 2022.02.15, 2022.02. 21-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.</p> <p>МУ-ын "Тавантолгой төмөр зам" ХХК нь БНХАУ-ын "Улсын эрчим хүчний хөрөнгө оруулалтын корпорац" /Чайна энержи/-тай 2022 онд 8 удаагийн цахим уулзалт зохион байгуулж, боомтын төмөр зам, шилжүүлэн ачих байгууламж, хөрөнгө оруулалт, нүүрсний худалдаа зэрэг асуудлыг үе шаттай цогцоор нь шийдвэрлэхээр хэлэлцсэн.</p> <p>"Эрдэнэс тавантолгой" ХК, Тавантолгой төмөр зам" ХХК болон "Чайна энержи" компаниудын хоорондын "МУ, БНХАУ-ын Гашуунсухайт-Ганцмод хил дамнансан төмөр зам барих болон нүүрс худалдах, худалдан авах урт хугацаатай гэрээ байгуулж хамтран ажиллах тухай ерөнхий зөвшилцөл (хэлэлцээр)"-ийг байгуулах асуудлаар хэлэлцээрийн төслийг СЯ, ЗГХЭГ, ХЗДХЯ-аар хянуулж, МУ-ын Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн хуралдаанд танилцуулж тус хэлэлцээрийг байгуулахыг дэмжсэн шийдвэр гарсан.</p> <p>БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И-гийн Монгол улсад албан ёсны айлчлал хийх үеэр /2022.08.06-07/ "МУ-ын СЯ, ЗТХЯ болон БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулсан.</p> <p>Санамж бичгийн дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК болон БНХАУ-ын "Чайна Энержи" ХХК-аас "Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хил дамнансан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр"-ийг 2022.08.08-ны өдөр Талууд цахимаар гарын үсэг зурж баталгаажуулсан.</p> <p>Хятадын зураг төслийн групп нь Монголын талд технологийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техник, эдийн засгийн үндэслэл /цаашид "ТЭЗҮ" гэх/, ажлын нарийвчилсан зураг төслийг боловсруулахтай холбогдуулан техникийн зөвлөх үйлчилгээний гэрээний төсөл болон ажлын даалгаврыг ирүүлсэн бөгөөд "Хятадын зураг төслийн групп"-ээс 2022.08.31-ний өдөр ТЭЗҮ, нарийвчилсан зураг төслийн нийт үнийн саналыг ирүүлсэн.</p> <p>Энэ хүрээнд хил холболтын төмөр замын ТЭЗҮ, барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилт болон тухайн ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлэх талаар ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр 2022.09.27, 2022.11.04-ний өдрүүдийн албан бичгээр танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>Хил холболтын төмөр замын ТЭЗҮ, барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах асуудлыг 2022.11.30-ны өдрийн Засгийн</p>	90

		<p>газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. <i>Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлүүдийн төмөр замын холболтын төсөл:</i> Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох холболтын 22 километр төмөр замын барилгын ажлыг 2021 оны 08 дугаар сараас эхлүүлсэн. Тус төмөр замаар 2022.07.09-ний өдөр туршилтын тээврийг эхлүүлсэн. Тус чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийг шалгаж 2022.06.23-25, 2022.09.05-07-ны өдрүүдэд техникийн комисс ажилласан. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><i>Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих төсөл:</i> ЗТХ-ийн сайдын 2021.12.23-ны өдрийн А/196 тоот тушаалаар техникийн комиссыг байгуулагдаж, Тавантолгой өртөөнөөс эхний 63 км-т ажиллаж дүгнэлт гаргасан. ЗТХС-ын 2022 оны А/106 дугаар тушаалаар 63-227 км гол зам, зөрлөгийн зам сум, гүүр хиймэл байгууламжид Техникийн комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах комисс ажиллуулах боломжтой гэж дүгнэсэн. ЗТХС-ын 2022.06.06-ны А/152 дугаар тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой өртөөнөөс Гашуунсухайт өртөө хүртэлх өртөө зөрлөгүүдийн болон ачилтын тойргийн дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбоо мэдээллийн байгууламж, шилэн кабель, технологийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах, урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комисс 2022.06.25-27-ны өдрүүдэд ажиллаж үүрэг даалгавар өгсөн. ЗТХС-ын 2022.08.31-ний өдрийн А/239 дүгээр тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын Тавантолгой өртөө, 4, 5, 6 дугаар зөрлөгийн дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбоо мэдээллийн байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажилласан. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><i>Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барих төсөл:</i> Төмөр замын барилгын ажлыг 2022 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөг батлуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.12.23-ны өдрийн А/196 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж төслийн 129-416 дугаар км-т техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.06.06-ны өдрийн А/152 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж төслийн үлдсэн 0-129 дүгээр км-ийг хүлээн авах техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасан. ЗТХС-ын 2022.08.31-ний өдрийн А/239 дүгээр тушаалын удирдамжийн дагуу ТТ-ГС болон ТТ-ЗБ чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын дээд, доод бүтцийг шалгаж ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах, техникийн комиссын өгсөн өмнөх үүрэг даалгаврын биелэлтийг шалгах Техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажиллаж, дүгнэлт гаргасан. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><u>2. Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төсөл:</u> Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 28 тогтоолоор уг төмөр замын төслийг концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт дахь зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам” төслийн концессын гэрээг “Монголиан транс лайн” ХХК болон “Монголиан транс ложистик” ХХК-ийн нэгдэлтэй байгуулах эрхийг 2022 оны 3 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар олгосон. Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 90 хувьтай байна. 2022.11.25-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Зүүнбаян- Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын тээврийн үйл ажиллагааг нээсэн.</p> <p><u>3. Тавантолгойн орд газрын Ханги боомттой холбох 477 км тусгай зориулалтын авто замын төсөл:</u> Концессын “Барих-зураг төсөл боловсруулах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа бөгөөд барилгын ажлын явц 42 хувьтай байна.</p>	
4	4.2.15. Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон автозамуудыг	<p>- Завхан аймгийн Нөмрөг сумыг Арцсуурь хилийн боомт чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн төсөлд Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад энэхүү зам барилгын ажлыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаж, шийдвэрлүүлэхээр холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2022 оны батлагдсан төсөвт тусгаагүй.</p> <p>- Алтай-Улиастай чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замын зураг төсөл 2013 онд боловсруулсан. Үлдэгдэл 60 км авто замын зураг төсөл 2022 онд боловсруулаж дууссан. Авто замын барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар</p>	30

	барина.	арчлалтын төсөл"-ийн 3-р шатны төслийн хүрээнд Алтай-Улиастай чиглэлийн авто замыг хэрэгжүүлэхээр АХБ-тай тохиролцож Сангийн яаманд холбогдох мэдээллийг хүргүүлж УИХ-аар соёрхон батлагдах ажил хүлээгдэж байна. Харин Нөмрөг-Арцсуурь чиглэлийн авто замыг АХБ-ны 4-р шатны хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	
НАЙМ.БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ			
Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.			
Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:			
5	8.1.1. Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барьж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Монгол Улс Азийн авто замын сүлжээнд 4 чиглэлээр хамрагддаг. 1. АН-3 чиглэлийн авто замд Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 1026.6 км авто зам Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.2 км авто замын өргөтгөл, шинэчлэлт 80%-ийн гүйцэтгэлтэй , Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн 2 дугаар үе шатны зам, барилгын ажил 60%-тай тус тус хэрэгжсэн. Улаанбаатар-Дархан чиглэлийн 4 эгнээ авто замын төслийн эхний ээлжийн 2 эгнээ замын үндсэн ажлууд болох гүүр, хоолой хиймэл байгууламж, далан, суурь, суурь хучилтын ажлыг 2022.10.30-ны өдөр дуусгаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. Тухайн төслийн гүйцэтгэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний хүрээнд авто замыг 2023.10.30-ны өдөр бүрэн ашиглалтад оруулна. 2. АН-4 буюу Новосибирск-Барнаул- Горно-Алтайск-Ташанта-Улаан байшинт-Ховд- Ярантай-Такешкен-Өрөмч- Каши-Хонкираф чиглэлийн авто замын сүлжээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр нийт 756 км авто замыг дайран өнгөрдөг. Монгол Улсын Засгийн газраас энэхүү авто замын сүлжээг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч Улсын төсөв, АХБ-ны зээл, тусламж, БНХАУ-ын ЕХИМ банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр үе шаттайгаар барьж байгуулан нийт сүлжээний 730.2 км буюу 90 гаруй хувийг ашиглалтад оруулсан. Үлдсэн “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 2 дугаар шатны хүрээнд Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замыг Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн. Авто замын барилгын ажил бүрэн дуусч 2022.10.29-ний өдөр 06/13/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.	100
6	8.1.2. стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барьж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам, тээврийн дэд бүтцийг өргөжүүлнэ.	Төмөр замын төслүүд, хилийн боомтуудыг холбох хатуу хучилттай авто замын төслүүдийн барилгын ажил, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилт тусгагдаагүй бөгөөд санхүүжилтийг шийдвэрлүүлэх чиглэлээр төлөвлөн дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд: <u>1. Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбох төсөл:</u> Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг тогтоосон хэлэлцээрийг 2021.11.18-ны өдөр хоёр улсын Гадаад харилцааны яамдууд ноот бичиг харилцан солилцож байгуулсан. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын асуудлаар Монгол-Хятадын хоёр талын газрын дарга нарын түвшний цахим уулзалтыг 2022.02.15, 2022.02. 21-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан. МУ-ын "Тавантолгой төмөр зам" ХХК нь БНХАУ-ын "Улсын эрчим хүчний хөрөнгө оруулалтын корпорац" /Чайна энерги/-тай 2022 онд 8 удаагийн цахим уулзалт зохион байгуулж, боомтын төмөр зам, шилжүүлэн ачих байгууламж, хөрөнгө оруулалт, нүүрсний худалдаа зэрэг асуудлыг үе шаттай цогцоор нь шийдвэрлэхээр хэлэлцсэн. “Эрдэнэс тавантолгой” ХК, Тавантолгой төмөр зам” ХХК болон “Чайна энерги” компаниудын хоорондын “МУ, БНХАУ-ын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам барих болон нүүрс худалдах, худалдан авах урт хугацаатай гэрээ байгуулж хамтран ажиллах тухай ерөнхий зөвшилцөл (хэлэлцээр)”-ийг байгуулах асуудлаар хэлэлцээрийн төслийг СЯ, ЗГХЭГ, ХЗДХЯ-аар хянуулж, МУ-ын Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн хуралдаанд танилцуулж тус хэлэлцээрийг байгуулахыг дэмжсэн шийдвэр гарсан. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И-гийн Монгол улсад албан ёсны айлчлал хийх үеэр /2022.08.06-07/ “МУ-ын СЯ, ЗТХЯ болон БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсан. Санамж бичгийн дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” ХХК-аас “Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий	90

		<p>хэлэлцээр”-ийг 2022.08.08-ны өдөр Талууд цахимаар гарын үсэг зурж баталгаажуулсан. Хятадын зураг төслийн групп нь Монголын талд технологийн хэрэгцээ шаардлагад нийцсэн техник, эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, ажлын нарийвчилсан зураг төслийг боловсруулахтай холбогдуулан техникийн зөвлөх үйлчилгээний гэрээний төсөл болон ажлын даалгаврыг ирүүлсэн бөгөөд “Хятадын зураг төслийн групп”-ээс 2022.08.31-ний өдөр ТЭЗҮ, нарийвчилсан зураг төслийн нийт үнийн саналыг ирүүлсэн.</p> <p>Энэ хүрээнд хил холболтын төмөр замын ТЭЗҮ, барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилт болон тухайн ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлэх талаар ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр 2022.09.27, 2022.11.04-ний өдрүүдийн албан бичгээр танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. Хил холболтын төмөр замын ТЭЗҮ, барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах асуудлыг 2022.11.30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p><i>Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлүүдийн төмөр замын холболтын төсөл:</i> Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох холболтын 22 километр төмөр замын барилгын ажлыг 2021 оны 08 дугаар сараас эхлүүлсэн. Тус төмөр замаар 2022.07.09-ний өдөр туршилтын тээврийг эхлүүлсэн. Тус чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийг шалгаж 2022.06.23-25, 2022.09.05-07-ны өдрүүдэд техникийн комисс ажилласан. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><i>Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих төсөл:</i> ЗТХ-ийн сайдын 2021.12.23-ны өдрийн А/196 тоот тушаалаар техникийн комиссыг байгуулагдаж, Тавантолгой өртөөнөөс эхний 63 км-т ажиллаж дүгнэлт гаргасан. ЗТХС-ын 2022 оны А/106 дугаар тушаалаар 63-227 км гол зам, зөрлөгийн зам сум, гүүр хиймэл байгууламжид Техникийн комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах комисс ажиллуулах боломжтой гэж дүгнэсэн. ЗТХС-ын 2022.06.06-ны А/152 дугаар тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой өртөөнөөс Гашуунсухайт өртөө хүртэлх өртөө зөрлөгүүдийн болон ачилтын тойргийн дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбоо мэдээллийн байгууламж, шилэн кабель, технологийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах, урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комисс 2022.06.25-27-ны өдрүүдэд ажиллаж үүрэг даалгавар өгсөн. ЗТХС-ын 2022.08.31-ний өдрийн А/239 дүгээр тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын Тавантолгой өртөө, 4, 5, 6 дугаар зөрлөгийн дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбоо мэдээллийн байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажилласан. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><i>Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барих төсөл:</i> Төмөр замын барилгын ажлыг 2022 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөг батлуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.12.23-ны өдрийн А/196 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж төслийн 129-416 дугаар км-т техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.06.06-ны өдрийн А/152 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж төслийн үлдсэн 0-129 дүгээр км-ийг хүлээн авах техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасан. Техникийн комисс ажилласнаар зүгшрүүлэх тээврийг эхлүүлээд байна. Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 99 хувьтай байна. Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.</p> <p><u>2. Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төсөл:</u> Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 28 тогтоолоор уг төмөр замын төслийг концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт дахь зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам” төслийн концессын гэрээг “Монголиан транс лан” ХХК болон “Монголиан транс ложистик” ХХК-ийн нэгдэлтэй байгуулах эрхийг 2022 оны 3 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар олгосон. Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 90 хувьтай байна. 2022.11.25-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Зүүнбаян- Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын тээврийн үйл ажиллагааг нээсэн.</p>	
--	--	--	--

		<u>3. Тавантолгойн орд газрын Ханги боомттой холбох 477 км тусгай зориулалтын авто замын төсөл:</u> Концессын “Барих-зураг төсөл боловсруулах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа бөгөөд барилгын ажлын явц 42 хувьтай байна.	
7	8.1.3. байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, үндэсний тээвэр логикийн тогтолцоог хөгжүүлнэ.	<p><i>Байгаль ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр</i> ЗТХС, 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021, 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд Улаанбаатар хотод цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 2, Хэнтий аймагт 3, Өмнөговь аймагт 7, нийт 12, хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийг цэнэглэх станц орон нутагт 1, Улаанбаатар хотод 4, нийт 5-ыг байгуулсан. Улсын хэмжээнд 20-60 квт-ийн хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, автотээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх станц 21 аймагт 80, Улаанбаатар хотод 54-г үйлчилгээнд ашиглаж байна. Нийслэлийн 8 байршилд шинээр өндөр хүчин чадалтай цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 25 станц барих санхүүжилтийг 2023 оны АОББ сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Олон улс улсын чанартай авто замын дагуу зогсоол байгуулах дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх зогсоолын байршлыг нарийвчлан тогтоож, хийгдэх ажлыг тодорхойлох ажлаар 2022 оны 5 дугаар сард газар дээр нь ажилласан.</p> <p>Тогтоосон байршил хийгдэх ажлын дагуу олон улс, улсын чанартай авто замын дагуу 2022 онд 15 цэгт амрах талбай барих, 4 цэгт зогсоол тохижуулах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/188 дугаартай тушаал гарсан.</p> <p>Тушаалын дагуу нийт 15 байршилд зогсоол барих, 4 байршилд зогсоол тохижуулах ажил хийгдсэн.</p> <p><i>Тээвэр логикийн сүлжээг сайжруулах чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> - Гашуунсухайт боомтод жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал байгуулж, 2021.09.20-ны өдөр ашиглалтад оруулсан. - Шивээхүрэн боомтод 17 га талбайд 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилдээ 10 сая тн нүүрс экспортлох чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг Нарийн сухайтын нүүрсний бүлэг орд орчмын “Монголын Алт” ХХК тэргүүлсэн 8 аж ахуйн нэгж хийж гүйцэтгэн 2022 онд ашиглалтад оруулсан. - Засгийн газрын 2022 оны 27 дугаар тогтоолын дагуу Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0119 анги Замын-Үүд-Эрээн боомтын дундын бүсэд чингэлэг шилжүүлэн ачих талбайн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан. - Тавантолгойн холимог тээврийн логикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж, логикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” ХХК ажиллаж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 40%-тай явагдаж байна. - “Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логикийн нэгдсэн төв байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байр зүйн зураг боловсруулах” гэрээт ажлын эхлэл болон дунд шатны тайланг дүгнэсэн. - Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Холимог тээврийн логикийн төвийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 800 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг БХБЯ-нд хүргүүлсэн. 	100
8	8.1.6. орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	<p>Орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөжүүлэх, ашиглалтыг сайжруулах зорилтын хүрээнд Ховд аймгийн Ховд, Хөвсгөл аймгийн Мөрөн, Хатгал, Дорнод аймгийн Чойбалсан, Увс аймгийн Дэглий цагаан, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт нисэх буудлуудыг шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх төрлөөр Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад оруулах саналыг Зам, тээврийн хөгжлийн яамны 2021.05.20-ны 03/2181, 2022.01.13-ны 01/133 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>Ховдын Булган, Хэнтийн Дадал сумын нисэх буудлуудын аэродромын их засварын “Ажлын даалгавар”-ыг баталгаажуулсан. Тус төслийг “Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх” төрлөөр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулахаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг ТХААГ-т /2022.01.13-ны 01/133 тоот/, ЭЗХЯ-нд /2022.02.23-ны 01/875 тоот/ тус тус хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас дээрх асуудлыг Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 14 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан.</p> <p>Ховд, Мөрөн нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (АИР)-ээр 2022.05.19-ний өдөр олон улсын нисэх буудал гэж зарласан.</p> <p>Ховд, Дэглий цагаан, Чойбалсан, Гурвансайхан, Өндөрхаан, Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг тус тус баталсан (2022.09.12-ны №18, 19, 20, 21), ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэрийг БХБ-ын сайдын төсөвт (Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв)-т тусган шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн.</p>	100

		<p>Жайка” ОУХАБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Чойбалсан нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгон хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна.</p> <p>Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг цагт 500 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай 14.000м² талбай бүхий зорчигч үйлчилгээний цогцолбор, нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхагтай болгох ажлын зураг төсөв боловсруулахад шаардагдах 300 сая, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 100 сая, нийт 400 сая төгрөгийн санхүүжилтийг Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэсэн. Тус ажлын гүйцэтгэгчээр “Эрхэс Констракшн” ХХК 2022.05.19-ний өдөр шалгарч, загвар зургийг (эскиз) 2022.08-р сард аймгийн Ерөнхий архитектораар батлуулсан бөгөөд ТЭЗҮ, барилга байгууламжийн иж бүрэн ажлын зургийг боловсруулсан, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т магадлалаар хянуулж байна.</p> <p>- Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон. 2021 оны 10 дугаар сарын байдлаар “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” 78.8%, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” 68%-ын хэрэгжилттэй.</p>	
9	8.1.7. инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг зам, тээврийн салбарт нэвтрүүлж, ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	<p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 тушаалаар “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр” (цаашид “Дэд хөтөлбөр” гэх)-ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Сайдын А/01 тушаалаар 2021 оныг “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласан. 2021 оны байдлаар нийт 58 үйлчилгээг цахимжуулсан байна. Үүнээс төрийн мэдээллийн нэгдсэн цонх “E-Mongolia” -оор дамжуулан 16, яам, харьяа байгууллагуудаас иргэд олон нийтэд интернэтээр дамжуулан 11, яам, харьяа байгууллагуудаас дотоод цахимаар 31 үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн үйлчилгээ (нийт 13 төрөл, ангилал) (https://license.mrtd.gov.mn/); - Авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагаа (Улаанбаатар хотын 4 ТАЦ) (http://203.91.118.110/mn); - Авто зогсоолын ухаалаг үйлчилгээ (Яамны гадна зогсоол) (http://ubparking.mn); - Салбарын шагнал, хүсэлт бүртгэлийн үйлчилгээ (https://award.mrtd.gov.mn); - Дотоодын ачаа тээврийн бүртгэл, зохицуулалтын үйлчилгээ (https://logistic.transdep.mn), (https://teeeverzuuch.mn); - Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, улсын дугаарын дуудлага худалдааны үйлчилгээ (https://www.transdep.mn); - Салбарын төсөл, хөтөлбөрийн удирдлага, хяналтын үйл ажиллагаа (http://projects.mrtd.gov.mn); - Иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, хяналтын үйлчилгээ (https://complain.able.mn); - Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын бүртгэл, тайлагналын үйл ажиллагаа (https://intranet.gov.mn); - Төрийн энтерпрайз архитектур, төлөвлөлтийн үйл ажиллагаа (https://ea.gov.mn) <p>зэргийг тус тус цахимжуулсан.</p> <p>Дэд хөтөлбөрийн суурь түвшин буюу 2020 онд Зам, тээврийн салбарт нийт 94 үйлчилгээ, үйл ажиллагаа бүртгэгдсэнээс 2021 онд 58-г нь цахимжуулж, цахимаар үзүүлэх үйлчилгээ 61%-д хүрсэн.</p> <p>Мөн цахим шилжилтийг эрчимжүүлэх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бататгах зорилгоор ЗТХЯ-наас хувийн хэвшлийн 4 байгууллага, аж ахуйн нэгжтэй Хамтран ажиллах санамж бичиг байгуулж, идэвхтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Цахим засаглалын эрх зүйн орчинг сайжруулах зорилтын хүрээд:</p> <ul style="list-style-type: none"> - Авто тээврийн дүрэмд “Салбарын мэдээллийн нэгдсэн сан”-тай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, батлуулсан. - Сангийн сайдын тушаалаар НӨАТ-ын буцаан олголтын журамд “авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг И-Баримтаар дамжуулан автоматаар суутган тооцож авах” талаар нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. <p>Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолт, Түргэний гүүрийн төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулж, дараа төлбөртэйгөөр тээврийн хэрэгслийг төлбөр авах цэгээр шууд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.</p> <p>Чадавхийг бэхжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд шинэ техник технологи нэвтрүүлж, 20 АЗЗА-д 42 ширхэг тусгай зориулалтын машиныг нийлүүлсэн. Ээлжит заварыг шинэ техник технолгиор гүйцэтгэх арга хэмжээ авч гадаргуун боловсруулалтын 2 төрлийн машиныг ЗТХТ ТӨҮГ-т хүлээлгэн өгч, ээлжит засварын ажил хийгдэж шинэ техник технологи нэвтэрсэн. Эмүльсийн үйлдвэр 2 ширхэгийг Харгуй ТӨХК, Хар Хорин ТӨХК АЗЗА, Эмүльс хадгалах 5-н ширхэг савыг холбогдох АЗЗА компаниудад нийлүүлсэн. Мөн ROMDAS машиныг ЗТХТ ТӨҮГ-т нийлүүлснээр Техник ашиглалтын түвшин тогтоох судалгаагны ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хийж эхэлсэн. Үндсэн</p>	100

		хөрөнгийн менежментийн системийг хэрэгжүүлж HDM4 сургалтад холбогдох мэргжилтнүүдийг сургаж байна.	
10	8.1.9. Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань, Дөргөн, Дарви, Хөшөөтийн чиглэлийн 160 км хатуу хучилттай автозамыг барих ажлын эхлүүлнэ.	<p>- Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдыг холбох авто замын барилгын ажлыг АХБ-ны “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Эрдэнэбүрэн сумыг холбох авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулах тендерийг зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй. Иймд ЗТХЯ-аас үнийн өсөлт, олон улсын нөхцөл байдлаас шалтгаалан зам барилгын ажлын төсөвт өртөгт дахин магадлал хийж төсөвт өртгийг нэмэгдүүлсэн бөгөөд АХБ-аас зөвшөөрөл авч дахин сонгон шалгаруулалт зарлахаар ажиллаж байна.</p> <p>- Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад тусган шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>- Хөшөөтийн уурхай нь Ховд аймгийн Цэцэг сумтай хатуу хучилттай авто замаар холбогдсон.</p> <p>- Ховд аймгийн Дарви сум нь Алтай-Ховд чиглэлийн А0304 дугаар бүхий улсын чанартай авто замын дагуу байрлаж байгаа ба хатуу хучилттай авто замаар холбогдсон.</p> <p>- Цэцэг сумыг Говь-Алтай-Ховд чиглэлийн А0304 улсын чанартай авто замтай холбох ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг Ховд аймгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	100
11	8.1.11. Өвөрхангай аймгийн Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын зам, Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Цогт-Овоо чиглэлийн босоо тэнхлэгийн ачаа тээврийн замуудын зураг төслийг боловсруулан, барьж эхлүүлэх ба баруун бүсийн А0301, А0302 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлын эхлүүлнэ.	<p>Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт хүртлэх авто замын зураг төслийн ажлыг дуусгасан.</p> <p>Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын замын барилгын ажил 2022 оны 4-р улиралд ажлын талбайд хөрс хуулах, ухмал, далан, хөлдөлтөөс хамгаалах үе, хатуу ухмал, суурийн доод үеийн ажил хийгдсэн. Барилгын ажлын явц 9.2 хувьтай байна.</p>	90
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ			
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.			
Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно:			
12	9.2.4. олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.	<p>- Улаанбаатар хотод одоогийн байдлаар 14 байршилд 53.2 км унадаг дугуйн зам ашиглагдаж байна. Цаашид 246.3 км замыг үе шаттай барьж байгуулснаар унадаг дугуйн замын тасралтгүй үргэлжлэх системийг бий болгож Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дугаар тушаалаар “Унадаг дугуйн зорчих орчин ба хэрэглээг хөгжүүлэх дэд хөтөлбөр” дэд хөтөлбөрийн зорилт хангагдана.</p> <p>Нийслэлийн хэмжээнд унадаг дугуйн замын 8 байршлын зураг төсөл боловсруулах ажлыг 2020 онд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ гүйцэтгэсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1335 захирамжаар Унадаг дугуйн замын барилгын ажлыг 2020-2021 онд он дамжин 2 багц болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ онд 3 байршилд 13.5 км дугуйн зам барьсан.</p> <p>Улаанбаатар хотын явган хүний зам болон дугуйн замын сүлжээг хөгжүүлэх ажлын зураг төслийн зөвлөх үйлчилгээний зураг төслийг “Гео зураглал” ХХК боловсруулсан. Тухайн зураг төслийн дагуу Нийслэлийн засаг даргын А/1261 захирамжаар батлагдсан “Авто замын байгууламжийн нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто замын тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган зам” ажлын хүрээнд 12 байршилд нийт 17488 м² явган замыг барьсан.</p> <p>- Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлж байгаа дугуйн замын багц 1 ажлын хүрээнд 2 байршлын 33.5 км, багц 2 ажлын хүрээнд 22.54 км дугуйн замын ажил үргэлжилж байна.</p> <p>- Хөдөө орон нутагт:</p> <p>Нийт 9 аймагт 31.6 км унадаг дугуйн замын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгуудын засаг дарга нартай байгуулсан гэрээнд унадаг дугуйн зам барих ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Орхон аймагт 2.7 км, Дорнод аймагт 5.5 км, Өвөрхангай аймагт 2.1 км, Завхан аймагт 6.7 км, Төв аймагт 5.6 км, Дархан-Уул аймагт 5 км, Өмнөговь аймагт 1.3 км, Дорноговь аймагт 2 км, Хэнтий аймагт 0.7 км унадаг дугуйн зам баригдаж дууссан.</p>	100
Зорилт 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:			

13	9.3.4. олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.	<p>Нийслэлийн Засаг даргын 2021.11.15-ны өдрийн А/900 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын 3 дугаар заалтад “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ” боловсруулах, 5 дугаар заалтад “Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ” боловсруулах, 6 дугаар заалтад “Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа” боловсруулах ажлууд тус тус хийгдсэн. НХААГ-21/226 тоот гэрээтэй “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ”, НХААГ-21/229 тоот гэрээтэй “Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлууд ажлын даалгаврын хүрээнд 100 хувь бүрэн дууссан.</p> <p>НХААГ-21/228 тоот гэрээтэй “Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ” боловсруулах ажлыг “Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн” НҮТББ, “Жоншт уул” ХХК нь хийж байна.</p> <p>УИХ-ын гишүүн Ц.Мөнх-оргилын санаачлагаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын, 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг “Үүлэн сүндэр” ХХК нь 2021 оноос хойш гүйцэтгэж байна. Иж бүрэн тохижуулахаар төлөвлөсөн Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн 2 зогсоолын ажил бүрэн дууссан ба 15 дундын зогсоолын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>- УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачлагаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянган авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар “Цагаан толгойн нуур” ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажил 20-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>- Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Чингэлтэй дүүргийн 17, 18-р хороонд Чингэлтэйн 5.1 км авто замыг шинэчлэх ажлын хүрээнд 2 эцсийн зогсоол, 17 дундын зогсоолыг тохижуулах ажлын зураг төсөлд саналаа тусгуулан ажиллаж байна. Зам талбайн ажил одоогоор эхлээгүй байна.</p> <p>-2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс Нийтийн тээврийн газраас 100 зогсоолын байршлыг тогтоож, 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах саналаа 2022 оны 2/233, 2/536 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус хүргүүлж төлөвлөгөөнд тусгуулсан.</p>	90
14	9.3.5. Богдхан төмөр замын төслийг түшиглэн “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	<p>“Хот төлөвлөлтийн судалгааны институт” ХХК-ийн зүгээс судалгааны ажлыг эхлүүлж эхлэлийн тайланг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр танилцуулсан.</p> <p>Богдхан төмөр замтай “Хөгжлийн алтан тойрог” буюу Улаанбаатар хотын дагуул хотуудыг холбосон замын ТЭЗҮ-ийг уялдуулахаар холбогдох саналыг Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Барилга хот, байгуулалтын яамнаас Богдхан төмөр замын шугамын чигийг Засгийн газрын хуралдаанаар оруулан тогтоогоод байна. Мөн Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д Засгийн газрын 2021.08.04-ний өдрийн 230 дугаар тогтоолоор олгосон.</p> <p>ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүргийн дагуу тус яамны ТНБД-ын шинэчлэн баталсан 2022.03.18-ны өдрийн 01 дугаартай ажлын даалгаврын хүрээнд Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2022.05.12-ны өдрийн 100/2022 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулан, ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн Дэд зөвлөлийн 2022.05.06-ны өдрийн хурлын 05 дугаар шийдвэр болон мөн яамны Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022.05.12-ны өдрийн 09 дүгээр шийдвэрээр тус тус хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>“Богдхан төмөр зам” төслийн замын дээд бүтцийн ажлын гүйцэтгэгч “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй байгуулах гэрээний төслийг боловсруулан, 2022.06.29-ний өдрийн МН/57 тоот албан бичгээр хүргүүлж харилцан тохиролцохоор ажиллаж байна.</p> <p>Төслийн эстакадан гүүр, туннелын ажлын ЕРС гэрээний төслийг 2022.06.21-ний өдрийн МН/64 тоот албан бичгээр “Бодь интернэшнл” ХХК-д хүргүүлж, гэрээний төслийг харилцан тохиролцохоор ажиллаж байна.</p> <p>Төслийн замын доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэгч Зэвсэгт хүчний жанжин штабтай 2022.07.07-ны өдрийн ТТЗ-МН22/03 дугаар гэрээг байгуулсан.</p> <p>Төслийн трассын дагуух газар чөлөөлөлтийн асуудлаар Нийслэлийн газрын харилцааны алба болон трасс дайран өнгөрч буй Сонгинохайрхан дүүрэг, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн газрын албатай хамтран Хан-Уул дүүрэгт 252, Сонгинохайрхан дүүрэгт 383 цахим өмчлөл бүхий нийт 635 нэгж талбараас одоогийн байдлаар 205 нэгж талбарыг шилжүүлээд байна.</p> <p>Богдхан төмөр зам төслийн ПК105+000-ПК142+500 хоорондох ажлын зураг батлагдсантай холбоотой 2022.08.27-ны өдөр төслийн талбайд Зэвсэгт хүчний 2 анги ПК108+000-ПК112+000 хүртэлх хэсэгт технологийн замын дүүргэлт, үндсэн болон түр репер цэг суулгах, машин механизм татан авалт, кемп нүүлгэн шилжүүлэлт зэрэг бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	100

		<p>2022.11.16-ны өдөр ПК132+300-ПК132+620 д байрлах сэтэрхийн 320 м газарт тэсэлгээ хийгдсэн. Уг тэсэлгээнээс гарсан суларсан хатуу ухмалын материалыг инженерийн зааварласан газар овоолго үүсгэн дуусгасан.</p> <p>Төслийн эхний 37,5 км болох ПК105+000-ПК142+500 хоорондох төмөр замын доод бүтцийн газар шорооны ажил 807,124.18 м3 буюу 24.83%, технологийн замын газар шорооны ажил 92,716.51 м3 буюу 100%-тай байна. Замын тэмдэг тэмдэглэгээний ажил хийгдэж дууссан.</p> <p>ПК105+000-ПК142+500 хоорондох 37.5 км-ийн барилга угсралтын ажилд ашиглах 4 худгийг гаргаж дууссан. /Худгаас усны нөөцийн савруу шахах холболт дутуу./</p> <p>2022.12.12-ны өдрийн байдлаар төслийн талбайд “Хорол Индего” ХХК, “Соте Кашмер” ХХК-иуд сэтэрхий /ухмал/-д тэсэлгээг хийж ухалт, зайлуулалтын ажлууд хийж байна. 2022 оны зам барилгын ажилд захиалагчийн хяналтын инженер хяналт тавин, зөвлөн туслан ажиллаж байна. Хяналт шалгалттай холбоотойгоор тус төслийн ажлыг түр зогсоогоод байна.</p>	
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ:			
15	9.5.2. Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.	Хөшигийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлсэн.	100
16	9.5.5. хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулна.	<p>Тус яам нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Автотээврийн хөгжлийн төв” ТӨҮГ,” Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран 2020 онд авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах 30 цэгийн байршлыг тодорхойлсон бөгөөд үүнээс 12 байршлыг аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр баталгаажуулсан.</p> <p>Өмнөх жилүүдэд дараах аймаг, сумдад автобуудал, авто замын дагуу үйлчилгээний цогцолбор барь ашиглалтад оруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөвсгөл аймгийн Мөрөн суманд автобуудлын барилгын өргөтгөл; - Хэнтий аймагт автобуудал; - Архангай аймгийн Цэцэрлэг суманд автобуудал; - Дорноговь аймгийн Сайншанд суманд автобуудал; - Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт улсын чанартай авто замын дагуу “Урьхан-2” үйлчилгээний цогцолбор; - Баян-Чандмань сумын нутаг дэвсгэрт Аглагийн хийд рүү эргэдэг уулзварын үйлчилгээний цогцолбор; - Төв аймагт улсын төсвийн хөрөнгөөр автобуудал; - Завхан аймгийн Улиастай суманд автобуудал; - Баянхонгор аймгийн Баянхонгор суманд автобуудал барьж үйл ажиллагаа эхлүүлсэн. - Увс аймгийн Улаангом сумын Цагаан дэглий нисэх буудлын хуучин барилгыг автобуудал болгон өөрчлөн тохижуулсан. - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвд Худалдааны төвийн барилгыг автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн зориулалтаар ашиглах асуудлыг ЗГ, УИХ-аар шийдвэр гаргуулж, “АТҮТ” ТӨҮГ хүлээж авсан. - Сэлэнгэ аймагт дахь “УБТЗ” ХНН-ийн автобуудлаас улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэх шийдвэр гаргуулж, үйл ажиллагаа эхлүүлсэн. <p>Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэр “Элсэн тасархай”-т “Сод хан трэвел” ХХК, Багануур дүүрэг “Минимакс”, Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт “Бумбат цогцолбор” зэрэг улсын чанартай авто зам дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд авто замын дагуу үйлчилгээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p> <p>2021 онд:</p> <ul style="list-style-type: none"> - “Алфароуд” ХХК нь Төв аймгийн Баян сумын нутагт өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулан ашиглалтад оруулсан. - “Нутаг хүнс трейд” ХХК нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйлчилгээний цогцолбор байгуулан ашиглалтад оруулсан. <p>2022 онд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд “Инсун мод” ХХК 2. Завхан аймгийн Сонгино суманд “Титан Би” ХХК 3. Архангай аймгийн Цэнхэр суманд “Заяын өгөөж” ХХК 	100

	<p>4. Булган аймгийн Хутаг өндөр суманд “Уньтын рашаан” ХХК 5. Төв аймгийн Баянцагаан суманд “Мандах бадрах булаг” ХХК өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолборыг барьж 2022 онд ашиглалтад оруулсан. “Аялал жуулчлалын гол чиглэл, олон улс, улсын чанартай авто замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл”-ийг хамтран хэрэгжүүлэх гэрээг МХАҮТ-аас 14 компанитай байгуулсан. Нийт 19 байршилд 9 тэрбумын хөрөнгө оруулалтаар 12 сарын хугацаанд барьж гүйцэтгэхээр гэрээнд тусгасан.</p>	
		93.1

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ